МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2026.01.18

Нэг. Зорилго, арга зүй

Иргэний нисэхийн үндэсний төв /ИНҮТ/ ТӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", мөн оны 183 дугаар тогтоолоор батлсан "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам", 2022 оны 352 дугаар тогтоолоор батлсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам", Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар батлсан "Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ИНҮТ ТӨХХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **78,3%**-тай үнэлэгдлээ.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжил-тийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш "үр дүнтэй"	60-84 хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа"	30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй"	0-29 хувь буюу "үр дүн гараагүй"	
5	3	-	2	-	72%

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 644. Буйр нуур олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын "4C" ангилал бүхий нисэх буудал байгуулах.
<u>Зорилтот түвшин:</u> Тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь-100

Биелэлт: *ИНЕГ-ын даргын 2024.09.30-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг Дорнод аймгийн Халхгол сумын "Сартуул худаг" орчимд нисэх буудал байгуулах байршлыг сонгосон. Энэхүү байршил нь "Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ"-нд заасан 25 км-т хамаарахгүй байгаа тул уг байршилд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагыг хангасан 4С хяналтын кодтой аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий нисэх буудал байгуулахад хамгийн тохиромжтой гэж дүгнэсэн.*
Нисэх буудлыг барьж байгуулахад нийт 110.5 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн урьдчилсан судалгаа гарсан бөгөөд зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, цаг уурын автомат станц суурилуулах төсвийг 2025 оны улсын төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлсэн боловч улсын төсөвт тусгаагүй. Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг (Халхгол сумаас 400км зайд орших) Олон улсын 4С ангиллын нисэх буудал болгон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өргөжүүлэхээр 2026 оны төсөвт тусгасан. 30%

2/ 654. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний дэд бүтцийг шинэчлэн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх.
Зорилтот түвшин: Улаанбаатар бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлын гүйцэтгэл, хувь-100
Биелэлт: *2025.03.20-ны өдөр 0325/2025 дугаар бүхий бүртгэлээр шинэчлэн боловсруулсан төсөвт магадлал хийж, баталгаажуулсан. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх 2025.02.27-ны өдөр 192/ШШ2025/01693 дугаартай шийдвэр гаргасан. Уг шийдвэрээр 5.1 тэрбум төгрөгийг "Үүрэг төрөйд" ХХК-аас гаргуулан Иргэний нисэхийн ерөнхий газарт төлүүлэхээр шийдвэрлэсэн.*
Зам, тээврийн сайдын 2025.01.22-ны өдрийн "2025 оны орлого зарлагын төлөвлөгөө батлах тухай" А/17 дугаар тушаалын дагуу "ИНУТ" ТӨХХК-ийн өөрийн орлогоос санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 7.5 тэрбум төгрөг суулгаж батлуулсан. Тус барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2025.04.11, 2025.05.20, 2025.08.01, 2025.10.03-ны өдрүүдэд зарласан боловч бүгд амжилтгүй болсон. Удаа дараа амжилтгүй болсон шалтгаанаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлээд байсан эрхийг "ИНУТ" ТӨХХК буцаан авч дээрх тендер хүчингүй болсон. Одоогоор тендерийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, шалгаруулалтыг дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна. 30%

2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжил-тийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш "үр дүнтэй"	60-84 хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа"	30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй"	0-29 хувь буюу "үр дүн гараагүй"	
6	1	-	5	-	41,7%

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 1.8.2.1. "Хөвд" нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх.

Зорилтот түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл-30%

Биелэлт: *"Ховд", "Мөрөн", "Чойбалсан" нисэх буудлыг 4С, "Гурвансайхан" нисэх буудлыг 4D ангиллын болгон ашиглалтыг сайжруулах төслийн мэдээллийг Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу боловсруулж, 2025.05.01-ний өдрийн 03/2018 албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. ЭЗХЯ-наас 2025.08.15-ны өдрийн 02/2201 дугаар албан бичгээр төслийн урьдчилсан үнэлгээний тайлан, дүгнэлтийг ирүүлсэн бөгөөд уг тайланд үндэслэн нийтэд урьдчилан зарлахад шаардлагатай мэдээллийг боловсруулж, 2025.09.22-ны өдрийн 02/4320 албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу төслийг нийтэд урьдчилан зарлах ажиллагаа хүлээгдэж байна. 30%*

2/ 1.8.2.2. "Мөрөн" нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх.

Зорилтот түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл-30%

Биелэлт: *"Мөрөн" нисэх буудлын ТЭЗҮ боловсруулах шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлсэн. /Дэлхийн банкны бүцалтгүй тусламж/ 2026 онд ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ. 30%*

3/ 1.8.2.3. "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх

Зорилтот түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл-30%

Биелэлт: *"Чойбалсан" нисэх буудлын (аэродромын) хөвөрч, буух зурвасыг олон улсын 4С ангилалын шаардлагад нийцүүлэн шинэчилэх ажлыг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд 59,120,000,000 төгрөгөөр тусгуулсан. Ирэх онд санхүүжих дүн 19,706,600 төгрөг. /УТ2602800955/ 30%*

4/ 1.8.2.4. Дорнод аймгийн Буйр нуур орчимд 4С нисэх буудал байгуулах.

Зорилтот түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл-10%

Биелэлт: *ИНЕГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг Дорнод аймгийн Халхгол сумын "Сартуул худаг" орчимд нисэх буудал байгуулах байршлыг сонгосон. Энэхүү байршил нь "Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ"-нд заасан 25 км-т хамаарахгүй байгаа тул уг байршилд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагыг хангасан 4С хяналтын кодтой аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий нисэх буудал байгуулахад хамгийн тохиромжтой гэж дүгнэсэн.*

Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг (Халхгол сумаас 400км зайд орших) Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу боловсруулж Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн. Одоогийн байдлаар Дорнод аймгийн Халхгол сумруу зорчигч урсгал бага, эрэлт байхгүй, зэрэгцээ 400км-т орших нисэх буудлыг Олон улсын иргэний нисэхийн 4С ангиллын нисэх буудал болгон өргөжүүлэхээр Засгийн газрын бодлого бариимтлан ажиллаж байх тул нэн шаардлагатай биш гэж үзэн хасах саналтай байна. 30%

5/ 1.8.2.5. "Гурвансайхан" нисэх буудлыг 4D ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх

Зорилтот түвшин: Барилгын ажлын гүйцэтгэл-30%

Биелэлт: *"Гурвансайхан" нисэх буудлын ТЭЗҮ боловсруулах шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлсэн. /Дэлхийн банкны бүцалтгүй тусламж/ 2026 онд ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ. 30%*

2.3. ИНҮТ ТӨХХК-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
60	34	26	-	-	90,5

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	хугацаа	Биелэлт	%
1	*3.6."Чингис хаан" олон улсын нисэх буудалд "Шатахуун хангамжийн байгууламж" байгуулах ажлыг эхлүүлэх.*	***I-II улиралд:*** *Улсын тусгай хэрэгцээний газар ашиглагч хуулийн этгээдүүдэд ажлын даалгаврыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.* ***III-IV улиралд:*** *Хуулийн этгээдүүдтэй хэлэлцээ хийж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана.*	*I-IV улирал*	*Холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын дуудлага худалдаа зохион байгуулж, агаарын тээврийн барилга, байгууламж, техвервемжийн талбай зориулалттай 3954 м2 газрыг "Сод Монгол Групп" ХХК-д, 4022 м2 газрыг "Интерстандарт Нефть" ХХК-д тус тус олгосон. ЗТС-ын 2025.02.14-ний өдрийн 09/703 дугаартай албан бичгээр дээрх компаниудад "Чингис хаан олон улсын нисэх буудал дахь агаарын хөлгийн Жет А-1 төрлийн шатахуун хангамжийн агуулах"-ын ажлын даалгаврыг хүргүүлж, төслийг хэрэгжүүлэх тооцоо, судалгааг боловсруулж ирүүлэх талаар мэдэгдэл хүргүүлсэн.* *Шатахуун хангалтын албыг ИНЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 54,807,986,166.68 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн хамт "Эрчис Ойл" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид 2025.03.31-ний өдөөр тасалбар болгон шилжүүлэн хүлээлцсэн.*	*50%*
2	*3.8."Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах ажлыг эхлүүлэх.*	***I-II улиралд:*** *Хөрөнгө оруулалт татах чиглэлээр өрөнхий судалгааг хийж, ИНЕГ-т хүргүүлсэн байна.*	*I-II улирал*	*"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн НҮБ-ийн Дэлхийн Хүнсний хөтөлбөрийн хүрээнд Хүмүүнлэгийн тусламжийн хариу арга хэмжээний төв байгуулах зорилгоор Зам, тээврийн сайдын 2025.03.20-ны өдрийн 03/1226 дугаартай албан бичгээр Батлан хамгаалах яамтай хамтран ажиллах*	*50%*

				хүсэлтээ шлэрхийлсэн бөгөөд хариу 1е/1445 дугаартай албан бичиг ирүүлсэн. Хүмүүнлэгийн тусламжийн төв байгууллахад Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газруудтай хамтран ажиллах шаардлагатай гэсэн хариуг ирүүлсэн. Иймд "ИНҮТ" ТӨХХК нь ЗТЯ-нд 2025.09.03-ны өдрийн 01-5/1271 тоот албан бичгээр "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах тухайд чиглэл өгөх хүсэлт албан бичиг илгээсэн бөгөөд одоогоор хариу өгөөгүй байна. *Тайлбар: 2025 онд хөрөнгө оруулалт татах чиглэлээр ерөнхий судалгаа хийгээгүй.*	
3	*5.2."ИНҮТ" ТӨХХК-ийн бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулах*	***I улиралд:*** *2024.1 дүгээр сард Бизнес төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-д хүргүүлж, батлуулсан байна.* ***II улиралд:*** *Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна.*	*I-IV улирал*	*"ИНҮТ" ТӨХХК-ийн 2024-2028 оны "Бизнес төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулж, гүйцэтгэх захиралд танилцуулсан.* *Гүйцэтгэх захирлын 2025.06.04-ний өдрийн А/335 дугаар тушаалаар "2025 оны Бизнес төлөвлөгөө", эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж, танилцуулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгээс "ИНҮТ" ТӨХХК-ийн 2024-2028 оны "Бизнес төлөвлөгөө"-г захирлын зөвлөл болон ТУЗ-д танилцуулах шаардлага хангаагүй тул зөвлөх үйлчилгээ авч хамтран боловсруулах нь зүйтэй." гэсэн шийдвэр гарсан.* *Иймд "ИНҮТ ТӨХХК-ийн 2026-2030 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө"-г боловсруулан батлуулах, үүний дараа компанийн "ИНҮТ" ТӨХХК-ийн "Бизнес төлөвлөгөө"-г батлуулах шаардлагатай гэж үзсэн.* *"ИНҮТ" ТӨХХК-ийн 2026-2030 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төслийг 2025.12.04-ний өдөр ИНҮТ-ийн удирдлагын хурлаар хэлэлцэж, хурлаас стратеги*	*50%*

				төлөвлөгөөний төслийг ТУЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэсэн.	
4	*5.7.Иргэний нисэхийн салбарт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх*	***I улиралд:*** *Төсөл, хөтөлбөрийн жагсаалт гаргаж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэх санал боловсруулж, ТУЗ-д хүргүүлсэн байна.* ***II улиралд:*** *Хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажилласан байна.* ***III-IV улиралд:*** *1-ээс доошгүй төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалт шийдвэрлэсэн байна.*	*I-IV улирал*	*2025 онд "ИНУТ" ТӨХХК-д хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж 2025.04.15-ны өдрийн 01-11/424 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. "Буянт-Ухаа" ОУНБ-д ГТҮШХА-ны тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг ашиглах, нэмэгдүүлэх замаар агаарын хөлгийн талбайн үйлчилгээ үзүүлж, орлогыг нэмэгдүүлэх төслийг 2025.02.07-ны өдөр боловсруулсан. Энэхүү төслийн дагуу "Буянт-Ухаа" ОУНБ-д агаарын хөлөгт газрын үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмж, тоноглолыг нэмэгдүүлж үйлчилгээг үзүүлсэн.*	*50%*

2.4. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
15	10	2	-	1	2	91.7%

Хэрэгжих шатанд байгаа арга хэмжээ:

1/ Эрх шилжүүлэх тухай. 2025.07.30 А/201
2.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэн, байгын ашиглалтад оруулахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК (Б.Отгонсүх)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод
Биелэлт: *Ажлын хэсэг барилга угсралтын ажилтай газар дээр нь танилцаж, нөхцөл байдлыг судлан гэрээг 2025.08.13-ны өдөр дүгнэж, 2025.08.15-ны өдөр №205 дугаартай нэмэлт гэрээ байгуулж барилгыг ашиглалтад хүлээлгэж өгөх хугацааг 2025.11.30-ны өдрийг хүртэл сунгасан. "Барилга эрч" ХХК -с 2025 оны 3/70 тоот албан бичгээр "улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэнтий аймгийн Дадал суманд хэрэгжүүлж буй "Дэлүүн болдог" нисэх буудлын барилга угсралтын гэрээт ажлыг гүйцэтгэж дуусаж байгаа тул комисс ажиллуулах" хүсэлтийг ЗТЯ-нд хүргүүлсэн*

байна. ЗТЯ-ны 2025.12.02-ны өдрийн 10/5571 албан бичгийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийн санал дүгнэлтийг хавсарган зохих баримт бичгийн бүрдлийг бүцаан хүргүүлэхээр ажиллаж байна. 50%

2/ Ажлын хэсэг байгуулах тухай 2025.08.25 А/214
3. Аудитад хамрагдах чиглэл тус бүрд шаардлагатай Дэд ажлын хэсгүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК (Б.Отгонсүх), Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (Ж.Цолмон)-д болон дотоодын агаарын тээвэрлэгч, иргэний нисэхийн байгууллагуудад /ахд С.Батболд, нбд Б.Эрдэнэзаяа/
***Биелэлт:** Олон Улсын иргэний нисэхийн байгууллагаас 2026 онд хийгдэх шалгалтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.09.18-ны өдрийн А/506 дугаар тушаалаар 6 дэд ажлын хэсгийг томилсон.Тус ажлын хэсэг ЗТЯ болон ИНЕГ-ын тушаал, төлөвлөгөөг судалж, ажлын уялдааг хангах талаар ИНЕГ-ын хэлтсүүд болон компанийн салбар, нэгжүүдтэй 3 удаа уулзалт хийж, заагдсан ажлуудыг хуваарилан чиглэл өгч ажиллаж байна. Олон Улсын иргэний нисэхийн байгууллагын хяналт, шалгалтын бэлтгэлийг хангах дэд ажлын хэсгийн төлөвлөгөөг 2025.11.12-ны өдөр "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар батлуулан дэд ажлын хэсгүүдэд цахимаар /вайбөр групп/ болон 2025.11.17-ны өдрийн 191 дугаартай албан бичгээр Агаарын навигацийн үйлчилгээний газар, Нисэх буудлуудын үйлчилгээний газар, Нисэхийн аюулгүйн хамгаалалтын газар, Захиргаа, санхүү удирдлагын газарт тус тус хүргүүлсэн.Дэд ажлын хэсэг 2025.11.20-ны өдөр тус шалгалтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, CAT mission report-ийн агаарын навигацийн чиглэлээр илэрсэн нөхцөл байдлыг залруулах талаар хуралдаж, шаардлагатай авах арга хэмжээнүүдийг тодорхойлж ажилласан. 50%*

2.5. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
3	3	-	-	-	-	100%

2.6. Нэлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	88%
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	77,1%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	83,8%
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	79,2%
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	91,7%
Дүн		**85,5%**

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 8.2.3. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, Үйл ажиллагааны тайлан, Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ - мэдээлэл дутуу

2/ 8.3.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам – линк ажиллахгүй.

3/. 8.4.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл – байхгүй

2.7. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаан-даа	Хоцорсон	Мэдээлээ-гүй	
178	178	175	3		98.3%

Хэрэгжилт хангалтгүй:

1/ 4.1.2. Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт – 2 удаа хугацаа хоцорсон.

2/ 4.1.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – 1 удаа хугацаа хоцорсон.

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

ИНҮТ ТӨХХК нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа арга хэмжээнүүдийг хариуцах хэлтэс, албадыг нэр заан тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн боловч тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам болон ИНЕГ, ИНҮТ-ийн оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлоогүй, өөрийн чиг үүрэгт хамаарах ажлыг бүрэн оруулаагүй байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам" шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хэрэгжилтийн байдал:

1) ИНҮТ ТӨХХК-ийн үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны

төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нэлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **78,3%**-тай байна.

2) Дээрх үзүүлэлтүүдээс Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хамгийн бага буюу 41.7%-аар үнэлэгдсэн бөгөөд энэ нь олон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслүүд хэрэгжээгүйтэй холбоотой байна.

3) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 дүгээр сард яам болон харьяа байгууллагуудын "Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт"-д дотоод аудит хийхэд ИНҮТ ТӨХХК-ийн хэрэгжилт 14% буюу хангалтгүй үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ҮАГ	93	14	-	15%
ЗГХХГ	7	0	-	0%
Нийт	100	14	-	14%

Энэ нь зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, хугацааг бодитой тооцоолоогүй, хариуцах эзэн нь тодорхой бус төлөвлөсөн, хэрэгжилтийг баримтад суурилан тайлагнаагүй, нотлох баримтыг хавсарган ирүүлээгүй, дотоод аудитын асуудал хариуцсан нэгжийн хяналт сул зэргээс шалтгаалсан байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. ИНД-ээр гэрчилгээжсэн үйлчилгээнд ашуулгүй байдал, чанарын удирдлагыг тогтолцоог үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлэх сайжруулна.	7	95.8%
Зорилт 2. Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тавигдсан стандарт шаардлагад нийцүүлэн агаарын нивигацийн үйлчилгээний ашуулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг хангана.	12	96%
Зорилт 3. Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааг хангана.	12	80.8%
Зорилт 4. Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тавигдсан стандарт шаардлагад нийцсэн иргэний нисэхийн ашуулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хангана.	3	98.3%
Зорилт 5. Олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	10	78.8%
Зорилт 6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, компанийн засаглал, хүний нөөцийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	12	98.3%

Зорилт 7. Санхүүгийн ил тод байдлыг хангаж, компанийн санхүүг үр ашигтай удирдан зохион байгуулна.	4	93.2%
Нийт		**90,5%**

5) 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Үүнд:

- Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах, "Дэлүүн болдог" нисэх буудлын барилгын ажил, "Өлгий" нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажлыг хэрэгжүүлэх, "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв, сургалтын төв байгуулах, "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг өргөтгөх, "Шатахуун хангамжийн байгууламж", "Airport hotel", "Отгонтэнгэр", Буйр нуур "4С" ангилал бүхий нисэх буудал байгуулах ажлыг эхлүүлэх зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөсөн хугацаанд багтаан дуусгах;
- Өмнө батлагдсан хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журам зэрэг гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмуудыг компанийн дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах;
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах, Өр авлагыг барагдуулах, санхүүгийн сахилга батыг сайжруулахад анхаарч хяналтыг сайжруулах;
- Бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн болон хяналт-шинжилгээний журамд өөрчлөлт оруулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэх;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааг хангах зорилтын хүрээнд бодлогын бичиг баримтуудад туссан төсөл арга хэмжээ, ялангуяа нисэх буудлуудын бүтээн байгуулалтын ажлыг 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусган хэрэгжүүлж ажиллах;

2. "ИНҮТ" ТӨХХК-ийн бизнес төлөвлөгөө, хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журам зэрэг гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмуудыг компанийн дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах зэрэг санхүүжилт шаардахгүй хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг яаралтай дуусгах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3. Он дамжсан, хугацаа хэтэрсэн өр авлагыг барагдуулах, санхүүгийн сахилга батыг сайжруулахад анхаарч хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яаралтай батлан хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажиллах;

4. Байгууллагын эрсдлийг тодорхойлж, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах;

5. ИНҮТ ТӨХХК-ийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний тайланг дотоод аудитын нэгж хүлээн авч, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хяналт тавьж ажиллах, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт материалын хамт бүрэн тайлагнаж хэвших;

6. 2026 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
   - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ИНБЗГ болон ИНЕГ, ИНҮТ болон бусад харьяа байгууллага, компаниудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.
   - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

ТАНИЛЦСАН:

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН

ДЭД САЙД Г.ГАНБОЛД

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.ТУЯА

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.ГАНБОЛД

ХЯНАСАН:
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
С.ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ Д.БАЯРМАА

Хүснэгт1

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберийн хэрэгжилт	7	7	72	20
2	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	6	6	41.7	20
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	60	60	90.5	20
4	Сайдын тушаалын хэрэгжилт	87	55	90.9	10
5	ТНБД-ын тушаал	3	3	100	10
6	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	45	45	85.5	10
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	178	178	98.3	10
Нийт				**78.3**	